



# САНАЛ АВАХ БАЙР БЭЛТГЭХ

[www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)



**“Санал авах байр бэлтгэх заавар, саналын  
хайрцаг, бүхээгийн хэмжээ, загвар”**

*СЕХ-ны 2016 оны 15 дугаар тогтоолоор баталсан.*



# Санал авах байр бэлтгэх:

- Санал авах байрны байршил, хаягийг санал авах өдөр хүртэлх **14 хоногийн турш** нийтэд мэдээлнэ.
- Харьяа сум, дүүргийн Засаг дарга
  - Зааврын дагуу санал авах өдрөөс **5-аас доошгүй** хоногийн өмнө



# Санал авах байр бэлтгэх:

---

- Монгол Улсын төрийн далбаа
- Хаяг – хэмжээг байрнаас хамаарч тогтооно.
- Өнгө заагаагүй.

**“Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн  
нийслэлийн Чингэлтэй дүүргийн  
102 дугаар хэсэг дэх санал авах байр” гэх  
МЭТ.**





# Санал авах байранд байх зүйлс:

---

- ✓ Сонгогчдийн нэрийн жагсаалт;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тусгайлан тоногдсон 1-ээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээг;
- ✓ Төрийн сүлд бүхий саналын хайрцаг /санал тоолох төхөөрөмжийн/;
- ✓ Сонгогчдоос саналаа нууцаар бэлтгэхэд шаардагдах 2-оос доошгүй тооны бүхээг;
- ✓ Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, бүхээг;



# Санал авах байранд байх зүйлс:

---

- ✓ Сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд болон ажиглагчид үзүүлэх дэлгэц /телевизор/;
- ✓ Саналын хайрцагны хувийн дугаар бүхий лац;
- ✓ Саналын хуудсанд саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавар;
- ✓ Саналын хуудсанд санал тэмдэглэх зориулалтын үзэг;
- ✓ Ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч болон мэдээллийн технологийн даамал, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан нарын ажил үүргээ гүйцэтгэхэд хүрэлцэхүйц тооны ширээ, сандал, утас, факс, компьютер принтер;



# Санал авах байранд байх зүйлс:

---

- ✓ Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй хэсэгт цахилгаан үүсгүүр;
- ✓ Санал авах, санал тоолох ажиллагааг баримтжуулах видео камер;
- ✓ Ажиглагчдын ширээ, сандал;
- ✓ Саналын хуудсыг хадгалах сэйф, лацны тэмдэг.





# Санал авах байр:

---

- Тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.
- Санал тэмдэглэх бүхээгт:
  - сонгогч санал тэмдэглэх заавар,
  - зориулалтын үзэг болон тавиур /ширээ/
  - Сонгогчийн гар утсыг түр хадгалах хайрцаг, сав





# Санал авах байранд ХОРИГЛОНО:

---

- ✘ нам, эвсэл, хамтарсан намуудын сонгуулийн штаб, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч байрлах;
- ✘ ухуулга сурталчилгааны байр ажиллуулах;
- ✘ нэр дэвшигчийн уулзалт, хурал, цуглаан хийх;
- ✘ нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн, эсвэл түүнийг эсэргүүцсэн сурталчилгаа явуулах.



# Санал авах байранд ХОРИГЛОНО:

- ✘ Санал авах өдөр нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд байх.
  - Энэ заалт нь тэднийг саналаа өгөхөд хамаарахгүй.
- ✘ Сонгогч санал гар утас болон зураг авах, дүрс бичлэг хийх зориулалт бүхий бүх төрлийн техник хэрэгсэл хэрэглэх.



# Санал авах байрны аюулгүй байдал:

---

- Саналын хуудас хүлээн авснаас хойш цагдаагийн хамгаалалтад авна.
- Сонгуулийн хороод, тухайн шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, онцгой байдлын алба хариуцан гал, усны зэрэг гэнэтийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.
- Галын хор болон түүнийг хэрэглэх заавар байна.



[www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)